МОНГОЛ УЛС
# ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 07 өдөр Дугаар А/50 Мандалговь

Сумдын Засаг дарга, түүний Тамгын газрын 2017 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай

Монгол Улсын төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 40 дүгээр зүйлийн 40.4.2, 40.5 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан " Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний журам"-ын 12.1, 12.2, 12.5, 12.6 дах заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2018 оны 02 сарын 06-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн дүнг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр "Санаачлагатай сайн" үнэлгээ авч тэргүүн байр эзэлсэн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрыг "Өргөмжлөл" 2.000.000 /Хоёр сая/ төгрөгөөр шагнасугай.

Гурав. Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр "Санаачлагатай сайн" үнэлгээ авсан Сайнцагаан сумын Засаг дарга, Тамгын газрын дарга нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг цалингийн сандаа багтаан олгохыг дээрх сумын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

Дөрөв. Шагналд шаардагдах 2.090.000 / Хоёр сая ерэн мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Д.Нандинцэцэг/ нарт зөвшөөрсүгэй.

Тав. Хяналт шинжилгээний үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж сум, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн ажиллахыг сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

0200167

Аймгийн Засаг даргын 2018 оны 02 сарын 07-ны өдрийн тоот захирамжийн хавсралт

## Сумдын Засаг дарга, түүний Тамгын газрын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн Хяналт -шинжилгээ, үнэлгээний

| № | Сумдын нэр | Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ | | | | Үнэлгээний дундаж хувь | Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ | | | | Үнэлгээний дундаж хувь | Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ | | | | Үнэлгээний дундаж хувь | Ерөнхий хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр | Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилт | Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт | | Аймгийн Засаг даргаас сумын засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт | Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах | Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт | Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт | | Байгууллагын ил тод байдлын үнэлгээ | Төсөв санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс хөтлөлт, өмч хөрөнгийн | Шударга байдлын үнэлгээ | Хэрэглэгчийн үнэлгээ | | |
| 1 | Сайнцагаан | 92.4 | 90.9 | 92.9 | 92.1 | 92.06 | 93.8 | 95.3 | 91.6 | 90.6 | 92.83 | 92.0 | 90.6 | 92.5 | 75.6 | 87.68 | 90.85 |
| 2 | Адаацаг | 87.9 | 90.8 | 88.9 | 89.0 | 89,14 | 90.8 | 94.5 | 88.4 | 84.1 | 89.45 | 92.7 | 86.9 | 95.2 | 79.3 | 88.53 | 89,04 |
| 3 | Дэрэн | 83.2 | 85.6 | 89.1 | 94.0 | 87.99 | 87.4 | 94.0 | 86.6 | 79.8 | 86.95 | 69.2 | 86.0 | 95.2 | 75.3 | 81.43 | 85.45 |
| 4 | Говь-Угтаал | 85.7 | 84.1 | 89.2 | 76.3 | 83.81 | 84.6 | 92.6 | 81.6 | 82.8 | 85.40 | 79.5 | 88.6 | 90.4 | 79.1 | 84.4 | 84.54 |
| 5 | Дэлгэрцогт | 87 | 86.8 | 88.6 | 77.3 | 84.93 | 86.1 | 88.8 | 90.2 | 83.6 | 87.20 | 68.1 | 92.9 | 85.7 | 73.7 | 80.10 | 84.08 |
| 6 | Луус | 90 | 84.3 | 85.6 | 81.4 | 85,33 | 87.9 | 91.9 | 87.4 | 85.0 | 88,05 | 80.5 | 75.9 | 83.7 | 71.0 | 77.78 | 83.72 |
| 7 | Баянжаргалан | 88.2 | - | - | 81.7 | 84.90 | 81.6 | 89.2 | 91.6 | 74.6 | 84.20 | 76.2 | 79.3 | 93.0 | 68.2 | 79.10 | 82.75 |
| 8 | Сайхан-Овоо | 86.8 | 82.3 | 82.7 | 74.3 | 81.52 | 86.3 | 83.0 | 90.0 | 82.6 | 85.48 | 83.5 | 72.7 | 80.5 | 83.0 | 79.92 | 82.30 |
| 9 | Эрдэнэдалай | 88.63 | 79.3 | 74.1 | 76.7 | 79.69 | 87.4 | 85.7 | 88.0 | 81.3 | 85.61 | 84.2 | 82.4 | 76.7 | 82.5 | 81.45 | 82.25 |
| 10 | Дэлгэрхангай | 84.8 | 87.0 | 85.2 | 70.5 | 81.87 | 86.2 | 82.8 | 86.0 | 84.4 | 84.84 | 74.9 | 78.3 | 81.8 | 84.0 | 79,73 | 82.14 |
| 11 | Хулд | 85.7 | 81.8 | 81.4 | 80.8 | 82.43 | 86.3 | 86.0 | 82.6 | 80.3 | 83.79 | 77.4 | 78.8 | 73.5 | 81.1 | 77.71 | 81.31 |
| 12 | Өлзийт | 92.9 | - | - | 71.8 | 82.35 | 83.4 | 93.7 | 84.5 | 70.9 | 83.13 | 77.3 | 74.6 | 81.1 | 77.0 | 77.50 | 80.99 |
| 13 | Өндөршил | 80.1 | 83.6 | 80.0 | 67.8 | 77.86 | 85.5 | 93.8 | 85.1 | 85.1 | 87.38 | 80.5 | 86.5 | 72.2 | 66.9 | 76.53 | 80.59 |
| 14 | Гурвансайхан | 89 | 80.4 | 83.0 | 78.1 | 82,63 | 83.2 | 91.2 | 84.6 | 72.8 | 82,95 | 80.3 | 71.0 | 81.2 | 66.0 | 74.63 | 80.07 |
| 15 | Цагаандэлгэр | 85.6 | 77.4 | 78.5 | 72.4 | 78.48 | 82.7 | 88.3 | 87.1 | 77.8 | 83.98 | 81.7 | 72.8 | 80.7 | 74.7 | 77.48 | 80.00 |
| Дундаж хувь | | 87.2 | 84.2 | 84.6 | 78.5 | 83.7 | 86.3 | 90.3 | 87.0 | 81.0 | 86.2 | 80.6 | 81.2 | 84.2 | 75.8 | 80.5 | 83.43 |

Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс